



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 4/578

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXVIII 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 36 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/566 дугаар захирамжаар Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар (РД:9070354)-т эзэмшүүлсэн Мөрөн сумын 8 дугаар багт байршилтай төлөвлөлтийн 4171532 нэгж талбарын дугаар бүхий төрийн захиргааны байгууллагын зориулалттай 6049м² газрыг “Идэрчандмань” ХХК (РД:2863133)-д шилжүүлэн газрын зориулалтыг “Үйлчилгээтэй орон сууц”-ны зориулалттай болгон өөрчилж үлдсэн 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/566 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3.Захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд “Идэрчандмань” ХХК (РД:2863133)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ